**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 03 өдөр Дугаар Б/95 Хэрлэн сум

Г.Ариунчимэгийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3 дахь заалт, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтын шинэчилэн батлах тухай” 487 дугаар тогтоол, 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай” 241 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоол, 2023 оны “Төрийн албаны салбар зөвлөлийн салбар зөвлөл”-ийн 45 дугаар тогтоол, 2023 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гантөмөрийн Ариунчимэг нь төрийн албаны тусгай шалгалтанд тэнцсэн тул Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2023 оны 7 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Г.Ариунчимэгийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

| | | |
|---|---|---|
| Комиссын дарга: | Э.Мөнх-эрдэнэ: | Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| Гишүүд: | Б.Мөнхжаргал: | Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин,уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн |
| | Э.Ариунтунгалаг: | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч |
| | Т.Баяртуяа: | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нярав |

3.Г.Ариунчимэгийн үндсэн цалинг ТЗ-8 шатлалаар тогтоон,1200000 (сая хоёр зуун мянган) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийн 40 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Ариунчимэгт үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАНТУЛГА